




2025 03-р сар

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГААНЫ АЛБА

ИНФЛЯЦЫН ТҮВШИН УЛСЫН ХЭМЖЭЭНД 9.6%, УЛААНБААТАР ХОТОД 10.3%-Д ХҮРЧ ӨСЛӨӨ.

- Хоёрдугаар сард инфляцын түвшин Монголбанкны зорилтот интервал $6+/-2$ түвшнийг давж Улаанбаатар хотод 10.3 хувь буюу хоёр оронтой тоонд хүрч өслөө. Инфляцын оролцооны түвшинг барааны бүлгээр задлан үзвэл 2.6 хувийг ундаа, усны үнийн өсөлт, 2.1 нэгж хувийг орон сууц, цахилгаан, түлшний үнийн өсөлт голлон бүрдүүлжээ.
- Нийт хэрэглээний үнийн индексийн сагсанд байгаа 430 гаруй нэр төрлийн бараа бүтээгдэхүүний 56 хувийг импортын бараа бүтээгдэхүүн дангаар бүрдүүлдэг ба хоёрдугаар сард инфляцын 2.6 нэгж хувийг импортын барааны үнийн өсөлт бий болгожээ.

МОНГОЛБАНКНААС ИНФЛЯЦ, ЗЭЭЛИЙН ӨСӨЛТИЙГ ХЯЗГААРЛАХ ЗОРИЛГООР МӨНГӨНИЙ ОЛОН ТАЛТ ХАТУУ АРГА ХЭМЖЭЭ АВАХАА МЭДЭГДЭВ.

- Инфляц сүүлийн саруудад эрчимжсэнтэй холбоотойгоор Монголбанкнаас 3-р сарын 7-ны “Мөнгөний бодлогын хуралдаан”-аар бодлогын хүүг хоёр нэгж хувиар нэмэгдүүлж 12 хувьд хүргэх шийдвэр гаргалаа.
- Өмнө оны 11-р сараас нэмэгдсэн цахилгааны үнийн дам нөлөө хүлээлтээс өндөр байгаа болон энэ оны 5 сараас дулааны үнэ, харин 9 сараас усны үнэ өсөхтэй холбоотой инфляцын дарамт нэмэгдэж буй нь ийнхүү бодлогын хатуу арга хэмжээ авахад нөлөөлжээ.
- Бодлогын хүүг өсгөхөөс гадна өрхийн хэрэглээний зээлийн өр орлогын дээд хязгаарыг 50 хувь-иар шинэчлэн тогтоосон бөгөөд тэтгэвэр, тэтгэмжийн орлого барьцаалсан зээлийн хувьд зээлдэгч сарын төлөлтөө хийсний дараах үлдэгдэл нь амьжиргаааны доод түвшнээс (495 мянга) багагүй байхаар шийдвэрлэжээ.
- Шийдвэр гаргахаас өмнө өр орлогын харьцааны дээд хязгаар 60 хувь байсан ба тэтгэвэр, тэтгэмжийн зээлийн харьцаанд тодорхой хязгаар байгаагүй болно. Мөн тэтгэврийн зээлийн өр орлогын харьцаа шийдвэрээс өмнө үед 84 хувьд хүрээд байжээ. Үүнээс гадна 2024 онд нийт зээлийн өсөлт түүхэн дээд хэмжээг давж 10 их наяд төгрөгт хүрснээр банкны салбарын зээлийн үлдэгдэл 36.8 их наяд төгрөгт хүрч өсөөд байсан билээ.

НҮҮРСНИЙ ХИЛИЙН ҮНЭ БУУРЧ ЭКСПОРТЫН ОРЛОГО ӨМНӨ ОНООС 11 ХУВИАР БУУРЛАА.

- Эхний хоёр сарын байдлаар нүүрсний биет хэмжээ өмнө онтой адил буюу 10 сая тонн-д хүрсэн бол хилийн үнэ 84 ам.долларт хүрч өмнө оны мөн үеэс даруй 33 хувиар буурчээ. Улмаар нүүрсний экспортын орлогын бууралтаар дамжин эхний хоёр сарын байдлаар нийт экспорт 2 тэрбум ам.долларт хүрч өмнө оноос 11 хувиар буурсан үзүүлэлттэй байна.
- Харин импортын хувьд өмнө оноос 7 хувиар өссөн ба өсөлтийн дийлэнх хувийг хэрэглээний бараа бүтээгдэхүүний импортын өсөлт бүрдүүлжээ. Улмаар гадаад худалдааны тэнцэл 294 сая ам.долларын ашигтай гарсан хэдий ч өмнө оноос 54 хувиар буурсан байгаа юм.
- Экспортын орлого буурсны нөлөөгөөр төсвийн орлого хүлээлтээс доогуур буюу 4,024 тэрбум төгрөгт хүрсэн бол зардал 4,590 тэрбум төгрөгт хүрснээр төсвийн тэнцэл эхний хоёр сард 566 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.
- Сангийн сайд Б.Жавхлан-ын мэдээллэж буйгаар жилийн эхний хагаст орлогоос хамаарсан төсвийн тодотгол хийх нөхцөл үүсэхгүй ба экспортын орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээ авснаар жилийн эцэст төсөв алдагдалгүй гарах хүлээлттэй байна.

ИМПОРТЫН ӨСӨЛТ, ЭКСПОРТЫН БУУРАЛТЫН ЗӨРҮҮНД ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ 681 САЯ АМ.ДОЛЛАРЫН АЛДАГДАЛТАЙ ГАРЧЭЭ.

- Худалдааны алдагдал төлбөрийн тэнцэлд урсгал дансны алдагдлыг нэмэгдүүлж нэгдүгээр сард урсгал дансны алдагдал 522 сая ам.долларт хүрснээр төлбөрийн тэнцэл 681 сая ам.долларын алдагдалтай гарлаа. Улмаар 2024 оны эцэст 5.5 тэрбум ам.долларыг даваад байсан валютын нөөц буурч 2-р сард 4.7 тэрбум ам.долларт хүрчээ.
- Тиймээс он гарснаас хойш төгрөгийн ханш суларч 3-р сарын эцсийн байдлаар нэг ам.долларт 3,480 төгрөг ногдож байна. Энэ нь оны өмнөх мөн үетэй харьцуулахад 100 төгрөгөөр суларсан үзүүлэлт билээ.

ЗАСГИЙН ГАЗРААС ШИНЭ БОНД ГАРГАЖ “НОМАД”, “CENTURY II” БОНДООС БУЦААН ХУДАЛДАН АВАХ БАЙДЛААР ГАДААД ӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТ ХИЙЖЭЭ.

- Монгол Улсын Засгийн газар хоёрдугаар сард таван жилийн хугацаатай, 500 сая ам.долларын “Century IV” бондыг олон улсын зах зээлд 6.625 хувийн хүүтэйгээр амжилттай гаргалаа. Ингэснээр 2026 онд дуусах “Номад”, болон бондын үлдэгдэл төлбөрийг төсөвт дарамтгүйгээр төлөх, улмаар эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад эерэг нөлөөтэй талаар сангийн яамнаас мэдэгджээ.

2024 ОНЫ ЭЦЭСТ НЭРЛЭСЭН ДУНДАЖ ЦАЛИН 2.7 САЯ ТӨГРӨГТ ХҮРЧ ӨМНӨ ОНООС 20 ХУВИАР ӨССӨН БАЙНА.

- Сонгуулийн жилтэй холбоотойгоор 2024 онд төсвийн их тэлэлт явагдаж зардал 30 их наяд төгрөгийг давсан. Улмаар нэрлэсэн цалин болон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ өсч дотоод эрэлт эрчимжсэн билээ.
- Тэгвэл 2024 оны эцсийн байдлаар нэрлэсэн цалин 2,672 мянган төгрөгт хүрсэн бол голч цалин 2,229 мянган төгрөгийг давснаар өмнө онтой харьцуулахад тус тус 20 болон 25 хувиар өссөн байна. Салбараар нь задлан авч үзвэл хамгийн өндөр цалинтай нь уул уурхайн салбар буюу дундаж цалин 5,402 мянган төгрөг байгаа бол хамгийн доогуур цалинтай салбарт 1,679 мянган төгрөгөөр зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбар орж байна. Харин санхүүгийн салбарын ажилчдын дундаж цалин уул уурхайн дараа орох өндөр буюу 3,185 мянган төгрөг байгаа юм.
- Ажилгүйдлийн түвшин 2024 оны эцэст 5.3 хувьтай гарсан ба өмнө оны 3.9 хувиас өссөн үзүүлэлттэй байна.


ХУРААНГУЙ

ҮЗҮҮЛЭЛТҮҮД		НЭГЖ	ТАЙЛАНТ ХУГАЦАА	ӨМНӨХ ҮЕ	ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕ	ЖИЛИЙН ӨСӨЛТ
УЛИРЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД						
			2024Q4	2024Q3	2023Q4	
Бодит ДНБ	тэрбум төгрөг		32,054	22,829	30,567	4.9%
Ажилгүйдлийн түвшин	%		5.3%	6.1%	3.9%	35.9%
Дундаж нэрлэсэн цалин	мянган төгрөг		2,672	2,480	2,235	19.6%
Гадаад өр	мая ам.доллар		37,117	35,639	36,570	1.5%
САРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД						
			2025M02	2025M01	2024M02	
Гадаад худалдааны үзүүлэлтүүд						
Нийт экспорт	сая ам.доллар		2,005	1,019	2,240	-10.5%
Зэс	сая ам.доллар		553	264	445	24.3%
Нүүрс	сая ам.доллар		859	449	1,336	-35.7%
Нийт импорт	сая ам.доллар		1,711	973	1,596	7.2%
Хэрэглээ	сая ам.доллар		-607	-344	-507	19.7%
Аж үйлдвэр	сая ам.доллар		-125	-70	-152	-17.8%
Хөрөнгө оруулалт	сая ам.доллар		-582	-352	-567	2.6%
Шатахуун	сая ам.доллар		-392	-206	-367	6.8%
Тэнцэл	сая ам.доллар		294	46	644	-54%
Дэлхийн түүхий эдийн үнэ						
Зэс	\$/тонн		9,330	8,976	8,305	12.3%
Нүүрс	\$/тонн		113	125	129	-12.4%
Газрын тос	\$/баррель		75	78	82	-8.5%
Алт	\$/трой унц		2,894	2,707	2,024	43.0%
Улсын нэгдсэн төсөв						
Төсвийн тэнцэл	тэрбум төгрөг		-566	-493	1,343	-142.1%
Төсвийн орлого	тэрбум төгрөг		4,024	1,668	5,102	-21.1%
Төсвийн зардал	тэрбум төгрөг		-4,590	-2,161	-3,759	22.1%

ҮЗҮҮЛЭЛТҮҮД		НЭГЖ	ТАЙЛАНТ ХУГАЦАА	ӨМНӨХ ҮЕ	ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕ	ЖИЛИЙН ӨСӨЛТ
САРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД						
			2025M02	2025M01	2024M02	
Мөнгөний бодлого						
M2 нийлүүлэлт	тэрбум төгрөг		41,833	41,827	37,603	11.2%
ХҮИ (C2020)	индекс		154.8	154.1	141.2	9.6%
Бодлогын хүү	%		10.0%	10.0%	13.0%	-23.1%
Хүү ба ханш						
Ам долларын ханш (Эцсийн)	Төгрөг/\$		3,467	3,420	3,382	2.5%
Төгрөгийн хадгаламж	%		11.5%	11.7%	11.6%	-0.9%
Валютын хадгаламж	%		3.2%	3.5%	3.9%	-17.9%
Төгрөгийн зээл	%		17.1%	16.9%	17.0%	0.6%
Валютын зээл	%		9.4%	9.5%	9.4%	-0.8%
Гадаад валютын нөөц						
Нийт	сая ам.доллар		4,763	4,884	4,971	-4.2%

БОДИТ ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

■ Бодит ДНБ-ий өсөлт (C2015)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

АЖИЛГҮЙДЭЛ БА ЦАЛИН




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ГАДААД ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ




Эх сурвалж: Монголбанк

ДЭЛХИЙН ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭ



Эх сурвалж: ОУВС

УЛСЫН ТӨСВИЙН ТЭНЦЭЛ




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

УЛСЫН ГАДААД ӨР




Эх сурвалж: Монголбанк

ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ




Эх сурвалж: Монголбанк

УЛСЫН ИНФЛЯЦ




Эх сурвалж: Монголбанк

ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ




Эх сурвалж: Монголбанк

АМ ДОЛЛАРЫН ХАНШ



Эх сурвалж: Монголбанк

БАНКУУДЫН ДУНДАЖ ХҮҮ



Эх сурвалж: Монголбанк



ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЭЭЧ

Б. Анунжин

Цахим хаяг: anunjin.ba@golomtbank.com

ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЭЭЧ

О. Номуншүр

Цахим хаяг: nomunshur@golomtbank.com

ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЭЭЧ

С. Цацрал

Цахим хаяг: tsatsral.sa@golomtbank.com

АНХААРУУЛГА

Голомт банкны Эдийн засгийн судалгааны алба нь Монгол улсын макро эдийн засгийг бүхэлд нь хамарч судалдаг билээ. Энэхүү тайлан нь макро эдийн засгийн хамгийн сүүлийн үеийн өгөгдлийг ашигласан болно. Энэхүү тайланд тусгагдсан агуулга, санаа нь Голомт банкны байр суурийг илэрхийлэх албагүй болно. Голомт банкнаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр энэ тайлангийн аль нэг хэсгийг хуулбарлах, системд хадгалах, ямар нэг хэлбэрээр дамжуулах, цахим механик хэлбэрээр хувилах, бичлэг хийхийг хориглоно.